

“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Батлагдсан төсөв: 100.0 сая, Зарцуулсан төсөв 50,0 сая  
 Төлөвлөсөн үйл ажиллагаа: 2 зорилтын хүрээнд 22 үйл ажиллагаа  
 Биелэлт: Өөрийн үнэлгээ 95%, АЗДТГ-ын ХШҮХ 90%

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт	АЗДТГ-ын ХШҮХ
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хандлагыг нэмэгдүүлэх						
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтад төлөвлөлтийн дагуу хамруулах	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	71,4	73%	2020-2021 оны хичээлийн жилд үндсэн мэргэшлээр 11 эмч, 5 сувилагч, 2021-2022 онд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 27 эмч, 14 сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна. Дархлаажуулалтын сувилагчийн мэргэжил олгох сургалтад байгууллагын зардлаар 5 сувилагч, Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 5 сувилагч суралцсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 эмч төгсөж, 3 резидент эмч суралцаж байгаа бөгөөд 2022 онд Сувилахуйн төгсөлтийн дараах сургалтыг эрхлэхээр бэлтгэл ажлыг хангасан. 2021 онд төрийн санхүүжилтээр үндсэн мэргэшлээр суралцаж төгссөн 9 эмчээс Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 7 эмч, өрхийн эрүүл мэндийн төвд 1 хүүхдийн эмч тус тус ажиллаж байна. Докторын зэрэгтэй эмч 0,2%, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 6%-тай байна. Төгсөлтийн дараах сургалтад хамруулахаар төлөвлөсөн эмч мэргэжилтний эзлэх хувь 74%, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний хувь 12,8 байгаа нь өмнөх оноос 0,3%-аар нэмэгдсэн байна.	100%

					<i>Хэрэгжилт 100%</i>	
2	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	70%	75%	Орон нутагт нэн шаардлагатай компьютертомограф соронзон давтамж бүхий дүрс оношилгоо судлал, ангиограф судсан дотуурх эмчилгээ оношилгоо судлалаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 2 эмч суралцуулж, ажиллуулсан. 2022 онд дээрх оношилгооны аппарат дээр ажиллах хүний нөөц бэлдэх зорилгоор 2 эмч суралцуулах захиалга өгсөн. Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 75% байна.	100%
					<i>Хэрэгжилт 100%</i>	
3	Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хийх боломжоор хангах, судалгаа шинжилгээний ажил хийх, өгүүлэл нийтлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Судалгаа, шинжилгээний ажлын тоо, үр дүн	1	4	Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний хурлыг "Цар тахлын эсрэг бидний хувь нэмэр судлаач-2021" уриан дор цаг үеийн нөхцөл байдлын улмаас онлайн хэлбэрээр зохион байгуулж судлаач болон нийт эмч эмнэлгийн мэргэжилтэн оролцох, танилцах боломжийг бүрдүүлж ажилласан. Мөн алсын зайнаас оролцсон илтгэлийг "ZOOM" программ ашиглан хэлэлцүүлсэн. Эмч нарын эрдэм шинжилгээний хуралд 31 судлаач нарын 11 илтгэл, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний хуралд 52 судлаачийн 15 илтгэлийг амжилттай хэлэлцүүлж, шилдэг бүтээлүүдийг тодруулсан. Эрдэм шинжилгээний хуралд оролцсон 26 илтгэлийг "Анагаах увидас сэтгүүлд хэвлэн нийтийн хүртээл болгосон.	100%
		Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17%	17.5%	Нийт 83 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн судалгаа шинжилгээний ажил хийж, 26 илтгэлийг эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн байна. Мөн бодлогын түвшинд 2 удаагийн цахим судалгаа хийгдэж танилцуулсан. Нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 12%-ийг судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч,	68,6%

					эмнэлгийн мэргэжилтэн эзэлж байна. <i>Хэрэгжилт 68,6%</i>	
4	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	22,1%	23%	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/715 дугаар тушаалаар тайлант онд нийт 62 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг шинээр хамгаалж, 33 эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн зэргээ шинэчлэн хамгаалсан. Тухайлбал: – Зөвлөх зэрэг 8, үүнээс эмч 4, сувилагч 4 – Тэргүүлэх зэрэг 27, үүнээс эмч 7, сувилагч 17, эмнэлгийн бусад мэргэжилтэн 3 – Ахлах зэрэг 27, үүнээс эмч 13, сувилагч 11, эмнэлгийн бусад мэргэжилтэн 3 байна. 2020 онтой харьцуулахад зөвлөх зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 50%, тэргүүлэх зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 10% , ахлах зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 8%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
5	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, магистр, докторт суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Боловсролын зэрэгтэй эмчийн хувь	11,1%	11.1%	Эрүүл мэндийн салбар байгууллагуудын эмч, эрүүл мэндийн ажилтнуудаас боловсролын зэрэгтэй эмчийн эзлэх хувь 11.0% байна. Тайлант хугацаанд Анагаах ухааны магистрт 3 эмч, докторын зэрэгт 2 эмч тус тус суралцаж байна. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
6	Гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих	Мэдлэг, туршлагаа дэлгэрүүлсэн эмч, мэргэжилтний тоо	-	2	Коронавируст халдвар /ковид/-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй. 2022 оны төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөсөн. <i>Хэрэгжилт 0</i>	-
7	Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний мэдлэгийн түвшнийг үе шаттайгаар	Гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн	18,4%	18.6	Коронавируст халдвар /ковид/-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй.	-

	дээшлүүлэх, суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь			2022 оны төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөсөн.  <i>Хэрэгжилт 0</i>	
8	Эмнэлгийн практик шинэ төрлийн эмчилгээ нэвтрүүлэх	Эмнэлгийн практикт нэвтрүүлсэн шинэ төрлийн эмчилгээ үйлчилгээний тоо	5	3	Тайлант хугацаанд лавлагаа шатлалд 15 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, 21 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн. Тухайлбал: 1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн 1,1 тэрбум төгрөгийн төсвөөр бүдүүн шулуун гэдэсний дуран, ходоод бүдүүн гэдэсний дурангийн аппарат ариутгагч төхөөрөмж улаан хоолой ходоодны дуран, ургийн гажиг оношлох 4D ЭХО аппарат, дижитал рентген нийлүүлэгдсэн. Улсын төсвийн 2,5 тэрбум төгрөгөөр ангиографийн аппарат, компьютертомографийн аппарат нийлүүлэгдэж тархины харвалт, зүрхний шигдээсийг эрт илрүүлж, оношлох, эмчлэх чадавхыг нэмэгдүүлсэн. Тайлант хугацаанд ангиографийн аппаратаар 2 хүнд оношилгоо хийсэн. Мөн шинээр хүүхдийн ясны хагалгааны шинэ төрөл, ходоод тайрах хагалгааг нутагшуулсан. Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр нээгдсэн. 2.Хувийн хэвшлийн Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг нь, дүрс оношилгоонд дижитал рентген, ходоодны дуран, нүд болон чих хамар хоолойн бүрэн иж бүрдэлтэй кабинет шинээр, Ачит эмнэлэг өндөр хүчин чадал бүхий өнгөт ЭХО аппаратыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Медипас төрөлжсөн төв эмнэлэг нь лабораторийн чиглэлээр 8, эмчилгээний чиглэлээр 3, оношилгооны чиглэлээр 1, сувилахуйн чиглэлээр 1, нийт 13 төрлийн тусламж үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Эрхэст Оргил эмнэлэг унтуулгын болон төвөнхийн оношилгоо, хамрын мэс заслын дурангийн аппарат авч, хамрын дайвар, таславч нөхөх,	100%

					<p>хэнгэрэг нөхөх хагалгааг 20 хүнд хийсэн. Нейрон мэдрэлийн ортой эмнэлэг нь тархины цахилгаан бичлэгийг удаан хугацаанд хийх ЭЭГ-ийн аппаратыг авч, 562 хүүхдэд оношилгоо хийсэн байна. Шинэ эрин мед төрөлжсөн клиникт гэмтлийн тусламж үйлчилгээнд үеийн гиалуроны хүчил тарилгыг нэвтрүүлсэн.</p> <p>4.Улсын төсвийн 900 сая төгрөгийн санхүүжилтээр сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 4D ЭХО аппарат, биохимийн аппарат, шээсний хагас анализатораар хангагдаж, тоног төхөөрөмжийн хангалт 95%-д хүрсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 25179 шинжилгээ хийгдсэнээс 7,5% нь төлбөртэй хийгдсэн нь өмнөх оноос 2.8%-аар буурсан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>	
9	Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, хэрэглэх аргад суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлэх	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	3	10	<p>Төрөлжсөн мэргэшлийн 3-6 сарын хугацаатай сургалтад серологи судлалын техникчээр 1 техникчтэй гэрээ байгуулан суралцуулсан.</p> <p>Үе бүтээх солих мэс засал, эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, элэг цөс, нойр булчирхайн хавдрын мэс засал, хүүхдийн зүрх судас, компьютер томограф, рентген туяаны техникч, серологи судлалаар 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцсан. Үндсэн мэргэшлийн 2 жилийн хугацаатай сургалтад гэмтэл согог судлалаар 2 эмч, дүрс оношилгоо судлалаар 1 их эмч суралцаж байна.</p> <p>Тайлант хугацаанд шинэ дэвшилтэт технологийг ашиглах чиглэлээр 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж чадавхжсан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>	100%
10	Эрүүл мэндийн байгууллагууд цахим тоног төхөөрөмж ашиглан суралцах, эмчилгээ оношилгоонд	Цахим тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо	2	1	<p>Бүсийн оношилгооны төвд суурилагдсан зайн оношилгооны телемедициний хурлын төхөөрөмжөөр 268 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 1024 холбогдох удирдлага эмч, эмнэлгийн мэргэжилтэн</p>	

	ашиглах бүрдүүлэх	боломж			<p>оролцсон байна.</p> <p>Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна.</p> <p>Тайлант хугацаанд БОЭТ-ийн Төрөх тасгийн телемедициний төхөөрөмжөөр ЭХЭМҮТөвтэй 3 өвчтөний, зүрх судасны өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр зөвлөгөө авах шаардлагатай 32 өвчтөний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 115 хүний мэдээллийг оруулсан.</p> <p>Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize програмыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 178.9 сая төгрөгийн өртөг бүхий 45 суурин компьютер, 11 зөөврийн компьютер, 21 өнгөт принтерээр хангагдаж сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 90%-д хүрсэн.</p> <p>Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалт 33%-д хүрч, суурь үзүүлэлтээс 16%-аар нэмэгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>	100%
11	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох, ажлын байр сэлгэн ажиллах нөхцөлийг бий болгох	Сэлгэн ажилласан эмчийн тоо	-	3	<p>Тайлант хугацаанд 21 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст халдварын цар тахлын тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн</li> </ul>	100%

					<p>мэргэжилтнээс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг 1 сарын хугацаатай Халдварт өвчин судлалын үндэсний төвд сэлгэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувийн хэвшлийн 2 тусгаарлах эмнэлэгт Улаанбаатар хотоос уушгины эмч болон 2 дотрын эмч ирж ажилласан.</li> <li>- Мөнхийн үйлс эмнэлэгт уламжлалтын эмч 1 жилийн хугацаатай гэрээгээр ажилласан.</li> <li>- Их тавт эмнэлэгт чанарын алба, хоол үйлдвэрлэлд гэрээгээр зөвлөх эмч нарыг сэлгэн ажиллуулсан.</li> <li>- БОЭТ-ийн инженерийн албанаас тоног төхөөрөмжийн инженер хувийн хэвшлийн эмнэлгүүдэд гэрээгээр ажиллаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж үйлчилсэн.</li> </ul> <p>Коронавируст халдварын цар тахлын үед хувийн хэвшлийн үндсэн тусламж үйлчилгээний 5 их эмч, клиникийн 3 их эмч, 4 эм зүйч тусгаарлах эмнэлэг болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн угтах үйлчилгээ, бүртгэл мэдээллийн ажилтнаар сэлгэн ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	
12	Анагаах ухааны төрөлжсөн номын сан байгуулах	Номын сангийн тоо	2	-	<p>Эрүүл мэндийн газрын Анагаах ухааны төрөлжсөн номын санд Англи, Орос, Монгол хэлний 1000 орчим номын баяжилт хийж, “Цахим номын сан” үүлэн технологид суурилсан номын сангийн автоматжуулалтын олон улсын программ “МОНКОХА” программыг нэвтрүүлсэн. 2023 онд 1 анагаах ухааны төрөлжсөн номын сан байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан.</p> <p style="text-align: right;">Хугацаа болоогүй</p>	-
13	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулах	Уулзалт, зөвлөгөөний тоо, үр дүн	1	1	<p>1. Ковид-19-ын цар тахлын үед ЭМГ-ын дэргэд эмнэлзүйн баг, нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх эмч нарын багийг томилон ажиллуулсан. Тус багаас 4 удаагийн уулзалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 250 гаруй эмч эмнэлгийн</p>	100%

					<p>мэргэжилтэнд эмнэлзүйн чиглэлээр сургалт зохион байгуулсан. Эмнэлзүйн баг, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудыг оролцуулсан 1 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p> <p>2. Аймгийн ЗДТГ, ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын Чандмань-Эрдэнэ холбоо, клиникийн холбоод оролцсон “Коронавируст халдварын 3 дахь давалгааны бэлтгэл, хариу арга хэмжээний бэлэн байдал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p> <p>3. ДЭМБ, ЭМЯ, ЭЭХХЗГ хамтран зохион байгуулж буй “Орон нутаг дахь эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмж, удирдлага зохион байгуулалт, чанар аюулгүй байдал” сэдэвт бүсчилсэн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт ЭМГ-ын мэргэжилтнүүд, эм зүйч, эм найруулагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч, эм био бэлдмэлийн улсын хяналтын байцаагч, эмнэлгийн эм зүйн албаны дарга нар оролцлоо.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>	
14	<p>Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах</p>	<p>Ёс зүйн зөрчил гараагүй байх</p>	-	-	<p>ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь ЭМЯ болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр 34 удаагийн сургалт зохион байгуулж 1191 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 509 үйлчлүүлэгчийг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 1,6 дахин нэмэгдэж, Эрүүл мэндийн газарт ирсэн гомдол 3,5 дахин буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Соёлыг түгээе” аянд эрүүл мэндийн салбар байгууллагуудын хамт оролцож, "БАЯРЛАЛАА" "ТАЛАРХЛАА" цахим давлагааг өрнүүлснээр 630 талархал ирсэн байна.</p>	100%



					ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд зөрчил өргөдөл гомдол бүртгэгдээгүй. <i>Хэрэгжилт 100%</i>	
15	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, байгууллагын хөгжил удирдлага төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авах, судалгааны дүнг үндэслэн арга хэмжээг зохион байгуулах	Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн тоо, үр дүн	80%	-	Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн хөндлөнгийн судалгааг Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг хийсэн бөгөөд тус судалгаагаар эрүүл мэндийн салбарын үйлчилгээнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 90-95%-тай байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд: - Нотолгоонд суурилсан эмнэлзүйн тусламж үйлчилгээний UpToDate олон улсын сургалтад эрүүл мэндийн салбарын нийт 152 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Орон нутагт 2 сургагч багш бэлтгэсэн. - БОЭТ-д “Хөтөч” хөтөлбөрийн хүрээнд “Хөтөч brand” ХХК-ийн 8 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-аар нэмэгдсэн. - Өрхийн эрүүл мэндийн төв тус бүрт угтах үйлчилгээний туслах ажилтныг Улаан загалмайн хороо болон Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран ажилгүй 8 иргэнийг сонгон авч 1 сар ажиллуулж, цалин болох тус бүр 500,000 төгрөгийг Шүдний мэргэжилтнүүдийн холбоо нийгмийн хариуцлагын хүрээнд олгож ажилласан. Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн эмч, ажилчдад сэтгэл зүйн эрүүл мэнд, стресс менежмент хийх чадварыг олгох чиглэлээр сэтгэл зүйн бүлгийн ярилцлагыг үе шаттайгаар зохион байгуулсан. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
16	Эрүүл мэндийн байгууллагуудын	Сургалтад хамрагдсан	2	4	Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/105 тушаалаар Эрүүл мэндийн газрын үйл	

	менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	байгууллагын тоо			ажиллагааг сайжруулах зорилгоор MNS ISO/IEC 9001:20016 чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж, 30 албан хаагчийг манлайллыг хөгжүүлэх чиглэлээр үе шаттай сургалтад хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагын хагас бие даасан засаглал, гүйцэтгэлээр санхүүжих чиглэлээр сургалтад ЭМГ, БОЭТ, СӨЭМТ, ХХЭМБ-ын удирдлага болон холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
Дундаж 84,6%						
Зорилт 2. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.						
17	Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь, эмчлэн эрүүлжүүлсэн ажлын үр дүн	85%	80%-аас дээш	Эрүүл мэндийн салбарын ажилчдын 91% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр 3,2% /55/ нь эрүүл мэндийн эрсдэлтэй 10%/169/ нь нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай 11% /184/ нь амбулаториор онош тодруулж, эмчлүүлэх шаардлагатай дүгнэлт гарсан. Мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал эрхэлсэн төв байгууллагад илгээж онош тодруулах шаардлагатай ажилтан байхгүй байна. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдыг халдвараас сэргийлэх, дархлааг дэмжих арга хэмжээнд 100% хамруулсан. Эрүүл мэндийн ажилчдын эрүүл мэндийг дэмжин эмчилгээ шаардлагатай албан хаагчдад “Эмч” хөтөлбөрийн дэмжлэгийн сангаас 44,5 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон. Эрүүл мэндийн байгууллагууд ажлын байранд ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2.1 сая төгрөг зарцуулсан ба Эрүүл мэндийн байгууллагын үйлдвэрчний хорооноос 147 ажилтанд 2.4 сая төгрөгийн аминдэм, халдвар хамгааллын хэрэгслээр хангасан. Цар тахлын үед үүрэг	100%

					гүйцэтгэж байгаа Онцгой байдал, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газрын албан хаагч, багуудын ажилчдад амин дэмийн зардалд 29,4 сая төгрөгийг зарцуулсан байна. <i>Хэрэгжилт 100%</i>	
18	Эрүүл мэндийн салбарын ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулах	Тохижуулсан танхимын тоо	5	1	Тайлант хугацаанд Жаргалант сумын эрүүл мэндийн төв, 6 өрхийн эрүүл мэндийн төв ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх чийрэгжүүлэлт болон амрах нийт 7 өрөө, 1 душ бүхий өрөө, гал тогооны өрөө засаж тохижуулсан байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас Бадархундага рашаан сувиллын эмнэлэг, Шигтгэмэл шүдний эмнэлэг, Сөд эмийн сан зэрэг нь мөн ажилчдаа амрах тав тухтай орчинг бүрдүүлсэн байна. Ажиллагсдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зорилгоор засаж, тохижуулсан өрөө-12 <i>Хэрэгжилт 100%</i>	100%
19	Гэр болон түрээсийн орон сууцанд хамруулах	Хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	12	3	Эрүүл мэндийн салбарын нийт 14 ажилтан аймгийн ЗДТГ-аас түрээсийн орон сууцаар хангагдсан байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад түрээсийн орон сууцанд хамрагдсан ажилчдын тоо 11-ээр нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн Медипас төв эмнэлэг ажилчдынхаа нийгмийн асуудлыг дэмжиж, албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс байгууллагынхаа залуу гэр бүл болон өөрийн эзэмшлийн орон сууцгүй мөн Орхон аймагт шилжин ирсэн нийт 47 ажилтныг компанийн эзэмшлийн орон сууцаар хангасан байна. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
20	Ахмад эмч, сувилагч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж цаг үеийн мэдээллээр ханган хамтран эрүүл мэндийн арга хэмжээ зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	-	10%	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахал, хариу арга хэмжээний сургалтад 11 ахмад буюу нийт ахмад эмч, сувилагч нарын 3.1% нь сургалтад хамрагдаж, цаг үеийн мэдээллээр хангагдсан. Эрүүл мэндийн байгууллагаас тэтгэвэрт гарсан 80-аас дээш насны нийт 60 ахмадад гэрийн асаргаа	100%

					сувилгаа хийгдсэн. <i>Хэрэгжилт 70%</i>	
21	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн ажилчдын дэмжлэгт хамрагдсан хувь	-	25%	Цар тахлын голомтод ажиллаж буй эрүүл мэндийн ажилтныг дэмжиж Эрүүл мэндийн яамнаас 1348 эмч, эмнэлгийн ажилтанд нийт 969,4 сая төгрөгийн тэтгэмж, аймгийн Засаг даргын захирамжаар давхардсан тоогоор 460 эрүүл мэндийн ажилтанд 51,0 сая төгрөгийн урамшуулал, давхардсан тоогоор дайчлагдан ажилласан 250 эрүүл мэндийн ажилтанд илүү цагийн хөлс 161,4 сая төгрөгийг олгосон. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн ажилчид 100% дэмжлэгт хамрагдсан. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
22	Жил бүр аймгийн “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-ийг сонгон шалгаруулж, урамшуулдаг байх	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	-	1	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт үр бүтээлтэй хамт олноо хошуучлан манлайлан ажилласан эмч, эрүүл мэндийн ажилтнуудаас төрийн дээд одон медалиар -16, ЭМЯ-ны шагналаар -32, орон нутгийн шагналаар- 82 мэргэжилтэн тус тус шагнагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63%-аар нэмэгдсэн байна. “Эрдэнэт хотын өдөр”-ийг тохиолдуулан Монгол улсын гавьяат эмч 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2, Алтангадас одонгоор 1 эмч шагнуулсан. 2021 онд “Оны алдартан”-аар Мөнхсүндэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Жаргалсайхан, “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-аар Ачит эмнэлгийн ерөнхий эмч Б.Цэнджав нар тус тус шалгарсан. <i>Хэрэгжилт 100%</i>	100%
Дундаж 95%						
Нийт хэрэгжилтийн дундаж хувь-90%						

